



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит бус 03 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 03 дугаар хуралдаан 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр болов.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 03 дугаар хуралдаанаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45.4-т заасны дагуу МҮОНРТ-ийн 2023 оны нөхөн сонгуулийн төлбөргүй сурталчилгаа нэвтрүүлэх хуваарь, цагийг батлах” тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай) асуудлыг хэлэлцээд, хорооны хуралдааны 4 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос Аймаг, нийслэл, сум дүүргийн, иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн санал авах үйл ажиллагааг 2023 оны 06 сарын 18-ны өдөр зохион байгуулна. Аймаг, нийслэл, сум дүүргийн, иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуулийн сурталчилгааг Монгол улсын сонгуулийн ерөнхий хорооны 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 тоот тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь”-т заасны дагуу 2023 оны 06 сарын 03-ны өдөр эхлүүлж, 6 дугаар сарын 16-ны 24:00 цагаас өмнө зогсоохоор төвлөсөн байна. Тус хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4-т заасны дагуу олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх саналыг хянан үзэж, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө буюу 2023 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс өмнө батлах чиг үүрэгтэй. Энэ ажлын хүрээнд Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээс сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь цагийн саналыг хуульд заасан хугацаанд хүлээн авч, хууль, журамд нийцүүлэн хянах ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуулийн сурталчилгааг төлбөргүй нэвтрүүлэх хуваарь, цагийн саналыг хянаж үзээд, боловсруулсан холбогдох танилцуулга, тогтоолын төсөл, хавсралт хуваарь, цагийн хуваарийн төслийг тус тус хэлэлцээд, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2, 45.4 дэх хэсгүүдийг үндэслэн “Олон нийтийн радио, телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цаг батлах тухай” 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 47 тоот тогтоолыг хавсралтын хамт батлав. Тогтоолын хавсралтаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуулиар Олон нийтийн радио, телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг баталж, сонгуульд оролцож буй нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд олгосон сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийг Олон нийтийн радио, телевизээр

нэвтрүүлэхдээ батлагдсан хуваарь, цагийг мөрдөж ажиллахыг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захиралд, Олон нийтийн радио, телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг батлагдсан хуваарь, цагийн дагуу нэвтрүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газарт тус тус даалгав. Уг тогтоолыг хавсралтын хамт Сонгуулийн ерөнхий хороо, Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз, нөхөн сонгуульд нэр дэвшигч нам, эвсэлд албан тоотоор хүргүүлж, цахим хуудаст байршуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 03 дугаар хуралдаанаар тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 4 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 4 тогтоолыг хавсралтын хамт батлав. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 48 тоот тогтоолын хавсралтаар 8 хуулийн этгээдэд 8 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.8} дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 49 тоот тогтоолын хавсралтаар 8 хуулийн этгээдийн 8 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт болон Монгол таун онлайн экспресс ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 50 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэв.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-05-30